



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар

A/38

Амардалай

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 78 дугаар тогтоол, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 120 дугаар тушаалын 4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 10 дугаар хуралдаан, сумын Онцгой комиссын 07 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Коронавирус (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 03 дугаар сарын 31 ний өдрийн 08.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 30 ны өдрийн 06.00 цаг хүртэл сунгасугай.

Хоёр: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж удирдлага, арга зүйгээр хангаж, халдвар хамгааллын дэглэмийг сахиж ажиллахыг Сургуулийн захирал /А.Мөнхбаатар/, Цэцэрлэгийн эрхлэгч /Х.Эрдэнэтүяа/, Хүний эмч /Ш.Должин/ нарт даалгасугай.

Гурав: Сумаар дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг зогсоохгүй өнгөрүүлж, суманд нэвтэрч буй иргэд, тээврийн хэрэгслийг бүртгэж, халдвар хамгааллын дэглэмийг сахиж, постны байрын эд хөрөнгийг хүлээлцэн хариуцлагатай гүйцэтгэж ажиллахыг Онцгой комиссын ерөнхий жижүүр, постны жижүүр албан хаагчдад үүрэг болгосугай.

Дөрөв: Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт шалгалтыг хийж, иргэдийн PCR шинжилгээнд хяналт тавих шалгалтыг эрчимжүүлж, төв замын постонд жижүүр хийж, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн цагдаа /Б.Насанжаргал/-д үүрэг болгосугай.

Тав: Голомтын бүс нутгаас эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмчийн 13А маягт, ар гэрийн гачигдлаар ирэхээс бусад иргэдийг хүлээн авахгүй байж дээрх тохиолдлоор ирсэн иргэдийн PCR шинжилгээний хариуг сайтар нягтлан шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж, гэрийн ажиглалтанд байх хугацаанд тавих хяналтыг сайжруулж, мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг багийн Засаг дарга нар, Эрүүл мэндийн төвийн багийн эмч нарт тус тус үүрэг болгосугай.

Зургаа: Төв зам дээр гарах постны хуваарийг 2021 оны 04 дүгээр сарын 30 ны өдрийн дуустал өөрчлөн хавсралтаар баталсугай.

Долоо: Тусгаарлалтын байрыг тохижуулж, бэлэн болгон сумын Онцгой комисст хүлээлгэж өгөхийг Эрүүл мэндийн төвийн дарга /С.Батцэцэг/, ЗДТГ-ын дарга /С.Нарантунгалаг/, Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч /Х.Эрдэнэтүяа/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ

488010 108

